



ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН (ХА/RAC) САЛБАР ДАХЬ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ



БАГА ЭРЧИМ ХҮЧЭЭР ИЖИЛ ХЭМЖЭЭНД ХӨРГӨЖ, САЙН САЙХАН АЖ ТӨРӨХ!

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Эрчим хүчний хэмнэлт хийнэ гэдэг нь илүү бага эрчим хүч зарцуулаад ижил хэрэгцээг хангах ажлыг хийнэ гэсэн үг юм.

Жишээлбэл, эрчим хүчний хэмнэлттэй хөргөгч хуучин загвартай нь харьцуулахад бага эрчим хүч зарцуулаад таны хоол хүнсийг хүйтнээр нь хадгална. Үүний нэгэн адилаар агааржуулагч төхөөрөмжийн дамжуулах хоолой нь тусгаарлалт сайтай байвал тав тухтай орчин бий болгоход шаардагдах хөргөх ачаалал нь багасаж, эрчим хүч хэмнэдэг.

Хэрэв аливаа төхөөрөмж ижил хэмжээний ажлыг илүү бага эрчим хүч зарцуулж эсвэл ижил хэмжээний эрчим хүчээр илүү их ажил гүйцэтгэж байвал түүнийг эрчим хүч хэмнэж байна гэж нэрлэнэ. Эрчим хүчний хэмнэлт нь сүүлийн хэдэн арван жилд хурдтай өсч буй эрчим хүчний хэрэглээг зохицуулах буюу хязгаарлах арга замын нэг байх боломжтой.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

2050 онд дэлхийн дундаж температурын өсөлтийг 2 °C-аас хэтрүүлэхгүй байхын тулд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ёстой ба үүний 40 орчим хувьд эрчим хүчний хэмнэлт хийж хүрэх боломжтой.*

ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН САЛБАРТ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Ихэнх хөгжиж буй орнуудад сэрүүцүүлэх хэрэгцээ, шаардлагад зориулсан төхөөрөмжүүд эрчим хүч их хэрэглэдэг тул тус орнуудын нийт эрчим хүчний хэрэглээнийх нь үлэмж хувийг хөргөлт, агааржуулалтын салбар эзэлдэг ба олон оронд худалдааны болон орон иргэний барилгын салбарт энэ төрлийн эрчим хүчний хэрэглээ хурдацтай нэмэгдэж байна.



Цаашлаад хөгжиж буй орнуудад хөргөлт, агааржуулалтын зориулалттай төхөөрөмжийн тоо нэмэгдэж байгаа нь нэг талаас хүмүүсийн амьдралын түвшин сайжирсантай, нөгөөтэйгүүр тэдгээр бүтээгдэхүүнүүдийн үнэ буурсантай холбоотой.

Уг асуудал тухайн орнуудын эрчим хүчний сүлжээний цахилгаан үйлдвэрлэлд их хэмжээний ачаалал бий болгож, оргил ачаалаллыг мэдэгдэхүйцээр нэмж байгаа нь хөргөлт, агааржуулалтын салбарт эрчим хүчний хэмнэлт хийх, түүнийг дэмжих ажиллагааг үндэсний ашиг сонирхол болгосон. Үндэсний хэмжээнд эрчим хүчинд хэмнэлттэй хөргөлт, агааржуулалтын төхөөрөмж хэрэглэснээр хөргөлтөнд зориулж байгаа цахилгаан эрчим хүч болон малтмал түлшний хэрэглээ, цаашлаад бохирдлыг бууруулж эдийн засгийн хөгжлийг тогтвортой байлгана.

Жишээлбэл, халуун уур амьсгалтай (орчны өндөр температуртай) орнуудад агааржуулагч төхөөрөмж үдээс хойш илүү их эрчим хүч хэрэглэдэг учир хэрэглээ хамгийн их байх үеийн эрчим хүчний хэмнэлтийн нөлөө нь тухайн төхөөрөмжийг хэзээ хэрэглэж буйгаас мөн хамаарна. Оргил ачаалалын үед цахилгаан тасрах (electricity 'black-outs') эсвэл цахилгаан хүчдэлийн уналтаас шалтгаалж урьдчилан төлөвлөсөн хязгаарлалт, таслалт (electricity 'brown-out') хийхэд хүргэж болно.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Энэтхэгийн Мумбай, Шинэ Дели зэрэг хотуудад зуны улиралд эрчим хүчний оргил ачааллын 75-аас их хувийг худалдааны болон орон сууцны салбар дахь агааржуулагч төхөөрөмжийн хэрэглээ эзэлдэг.**

Эрчим хүчний хэмнэлт нь хөргөлт, агааржуулалтын салбарт олон төрлийн ашиг тустай:

- * Бүтээгдэхүүний ашиглах эрчим хүч, түүний ажиллагаа/засвар үйлчилгээний зардал буурснаар бизнес эрхлэгчид болон эцсийн хэрэглэгчдийн хувьд санхүүгийн зардлаа хэмнээд бүтээмж нэмэгдүүлэх боломж олгоно;
- * Төхөөрөмж/системийн хүчин чадал болоод хөргөх ачаалал хоорондоо илүү тохирно;
- * Малтмал түлш шатааж эрчим хүч үйлдвэрлэх гэх мэт хүний үйл ажиллагаанаас үүсэх ялгарлыг бууруулснаар эх Гарагаа дэлхийн дулаарлын нөлөөллөөс хамгаалж чадна.



ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?


Орчин үеийн эрчим хүчинд хэмнэлттэй хөргөгчнүүд 2001 онд үйлдвэрлэсэн хөргөгчнөөс даруй 40% бага эрчим хүч хэрэглэдэг.*



ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛ ГЭЖ ХЭНИЙГ ХЭЛЭХ ВЭ?

Эрчим хүчний хэмнэлт хийхийн ач холбогдлын талаар мэдэж байх хэрэгтэй хөргөлт, агааржуулалтын салбарын гол оролцогч талуудад дараах мэргэжилтнүүд хамаарна:

- ❄ Озоны Үндэсний Алба (OYA) болон төрийн бусад байгууллагууд;
- ❄ Орон нутгийн хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмж/бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, дилерүүд, угсралт суурилуулалт эрхлэгчид;
- ❄ Үндэсний, бүсийн болон олон улсын стандартчиллын байгууллагууд;
- ❄ Орон нутгийн цахилгаан эрчим хүч түгээх байгууллага;
- ❄ Эцсийн хэрэглэгчид, бизнесийнхэн;
- ❄ Банк болон бусад санхүүгийн байгууллагууд.



ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН САЛБАР



ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН САЛБАРТ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ ХИЙХИЙГ СУРТАЛЧЛАХАД ЯМАР БОДЛОГО/ХЭРЭГСЭЛ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хэдийгээр хөргөлт, агааржуулалтын төхөөрөмж ашиглалт дэлхий даяар эрчим хүчний хэрэглээнд нөлөөлж байгаа ч зарим хөгжиж буй орнуудад эрчим хүчний хэмнэлтийг сурталчлах бодлого, арга хэрэгслийг хэрэгжүүлж эхлээгүй байна.

Уг сурталчилгаанд дараах зүйлсийг хамруулан ойлгож болно. Үүнд:

- ❁ Эрчим хүчинд хэмнэлттэй хөргөлт, агааржуулалтын төхөөрөмж хэрэглэхийг барилгын салбарын хууль, журманд заавал эсвэл сайн дураар дагаж мөрдөх дүрэм журам болгон оруулах (жишээлбэл, барилгын дулаалгын заавал дагах журам);
- ❁ Эрчим хүчинд хэмнэлттэй хөргөлт, агааржуулалтын төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслүүдэд зориулсан импортын татварыг бууруулах, онцгой татаас өгөх эсвэл татварын таатай орчин бүрдүүлэх гэх мэт аргаар санхүүгийн болон/эсвэл өөр бусад урамшуулал үзүүлж, жижиг дунд үйлдвэрлэл болон түүнтэй төстэй байгууллагуудад хөрөнгө оруулалтын боломж олгох;
- ❁ Орон нутгийн цахилгаан эрчим хүч түгээх байгууллагатай хамтран зохистой хэрэгцээний менежментийн хөтөлбөр бий болгох;
- ❁ Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, маркетингийн кампанит ажил зохион байгуулах;
- ❁ Хэрэглэгчдийн итгэлийг олж, эрчим хүчний хэмнэлт хийхийн ач тусын талаар илүү мэдээлэл хүргэхийн тулд хөргөлт, агааржуулалтын төхөөрөмжтэй холбоотой стандарт, гэрчилгээ, шошгожуулах тогтолцоо гэх мэт чанарын баталгаажуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлж, хөгжүүлэх.



Эх үүсвэр:

1. Олон улсын эрчим хүчний агентлаг (IEA)
2. Эрчим хүч, байгаль орчин, усны зөвлөл (CEEW)**
3. "Уур амьсгалын өөрчлөлтийн Засгийн Газар хоорондын ажлын хэсэг" (IPCC)
4. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)
5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр (UN Environment)
6. АНУ-ын эрчим хүчний хэлтэс (US DOE)

Шошгожуулах тогтолцоо



Нэгдсэн үндэстний байгууллага
Эдийн засгийн салбар
OzonAction

1 Rue Miollis, Paris 75015, France

www.unep.org/ozonaction/
ozonaction@unep.org

Англи хэлнээс орчуулсан: А.Хэрлэнзаяа /БОАЖЯ-ны ОУА/
Хянасан: Проф. Ц.Адъяасүрэн /БОАЖЯ-ны ОУА-ны захирал/
Д.Дуламсүрэн /БОАЖЯ-ны ОУА-ны Ахлах мэргэжилтэн/